



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

Г “Юу Жи Эс” ХХК-д хөрөнгө оруулалтын зөвлөхийн Ү  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Юу Жи Эс” ХХК-д үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосугай.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Юу Жи Эс” ХХК/С.Баттөр/-д үүрэг болгосугай

3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН